



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2018 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 12.

Хэрлэн сум

Зардлын тухай

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 09 дүгээр сарын 7-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 мВт-аар өргөтгөх төслийн ТЭЗҮ боловсруулах зардал батлах тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрчим хүчний салбарын чиглэлд тусгагдсны дагуу зүүн бүс нутгийн эрчим хүчний чадлын өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангахуйц Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар нэмэгдүүлэн өргөтгөх төслийн техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, англи хэлний орчуулгын зардлыг 170,000,000.0 /нэг зуун далан сая/ төгрөгт багтаан, компанийн хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний хэмнэгдсэн зардлаар хийлгэх саналыг дэмжив.
2. Техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, орчуулгын ажилд шаардагдах зардлыг холбогдох хууль журмын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэхийг гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д даалгав” гэжээ.

ДАРГА



Ц.ТҮВШИНЗАЯА